Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, түүний дотор дотоод аудиторын тайлант оны ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар: Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас Ковид-19 цар тахлын улмаас санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-т заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгээгүй, хөтөлбөр арга хэмжээгээрх төсвийн гүйцэтгэлийн тайлан, хүрэх үр дүнгийн тайланг аудитад ирүүлээгүйг тайлангийн хугацаанд залруулан авсан.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 7,973,053.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 79,790.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80.0 хувиар буюу 63,784.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,861,020.1 мянган төгрөгөөр буюу 238.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, урьдчилж орсон орлого, хуримтлагдсан үр дүн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	13,867.4	46,177.0	32,309.6
Авлага	2,388.8	541.3	-1,847.5
Бараа материал	254,904.8	224,421.4	-30,483.4
Үндсэн хөрөнгө	509,619.0	2,370,660.4	1,861,041.4
Нийт хөрөнгө	780,780.0	2,641,800.1	1,861,020.1
Өр төлбөр	3,750.3	405.9	-3,344.4
Урьдчилж орсон орлого	9,489.9	45,003.8	35,513.9
Хуримтлагдсан үр дүн	767,539.8	2,596,390.4	1,828,850.6
Нийт өр төлбөр ба цэвэр өмч	780,780.0	2,641,800.1	1,861,020.1

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 46,177.0 мянган төгрөг болж 32,309.6 мянган төгрөгөөр өссөн нь замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өссөн;
- Авлага дансны үлдэгдэл 541.3 мянган төгрөг болж 1,847.5 мянган төгрөгөөр буурсан нь хувь хүнээс авах авлагыг бүрэн барагдуулсан;
- Бараа материалын дансны үлдэгдэл 224,421.4 мянган төгрөг болж 30,483.4 мянган төгрөгөөр буурсан нь улсын бүртгэлийн үйлчилгээнд ашигладаг үнэт цаасны нэр төрөл багассан;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,370,660.4 мянган төгрөг болж 1,861,041.4 мянган төгрөгөөр өссөн нь УБЕГ-аас үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 140,854.8 мянган төгрөг, хандив тусламжаар "Койка" олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас 1,811,774.5 мянган төгрөг, Багануур дүүргийн ЗДТГ-аас 19,633.3 мянган төгрөг, Хан-уул дүүргийн ЗДТГ-аас 4,417.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө шилжин ирсэн;
- Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны А/21 дүгээр тушаалаар 202,893.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хасаж акталсан;
- Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,378,602.4 мянган төгрөгөөр буюу 29.5 хувиар өссөн нь хандив тусламжаар "Койка" олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас 1,811,774.5 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж хүлээн авсан;
- Нийт зардал өмнөх оноос 681,554.0 мянган төгрөгөөр буюу 8.7 хувиар өссөн нь Ерөнхийлөгчийн сонгууль, нийслэлийн засаг даргын 2019 оны А/1355 дугаар захирамжаар шинээр нэмэгдсэн хорооны иргэдийн хаягийн мэдээллийн санд өөрчлөлт оруулж бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн, Нийслэлийн иргэдийн хурлын 2021 оны 98 дугаар тогтоолоор гудамжны "Нэршил солих"-д иргэдийн хаягийн мэдээлэлд өөрчлөлт оруулж бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн зэрэгтэй тус тус холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 6,231,679.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 6,231,679.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 42,587.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 6,274,266.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Батлагдсан төсвийг 258,225.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 6,532,491.7 мянган төгрөг болгон тодотгосон. Төсвийн төслийг нэмэгдүүлж баталсан болон тодотгол хийж нэмэгдүүлсэн нь тайлант онд 19 хороо шинээр нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 6,532,491.7 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 6,532,491.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 6,529,162.0 мянган төгрөгийг зарцуулж 3,329.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,529,162.0 мянган төгрөг буюу 99.95 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 2,902.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийн дутуу зарцуулалт нь Улсын бүртгэл, мэдээлэл хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардал арга хэмжээ 3,323.4 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал арга хэмжээ 6.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70406	Улсын бүртгэл, мэдээлэл	6,532,491.7	6,529,162.0	3,329.7	99.9
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	6,524,841.4	6,521,518.0	3,323.4	99.9
1.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	7,650.3	7,644.0	6.3	99.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц сан ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс 113,952.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 597,303.7 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 70,506.0 мянга, нийт 781,761.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 76,721.8 мянга, хангамж бараа материалын зардалд 73,339.5 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс 123,328.9 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 508,090.9 мянга, нийт 781,481.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 280.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Тус нэмэлт санхүүжилтийн орлого нь Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус төв нь тайлант онд түрээсийн байрнаасаа гарч Улсын бүртгэлийн ерөнхий газрын өмнө нь байрлаж байсан түрээсийн байранд нүүж орсон. Тус шинээр нүүж орсон түрээсийн байрны түрээсийн гэрээ нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын нэр дээр тул тус байгууллагын түрээсийн зардлыг хариуцан төлсөн байна. Харин 2022 оноос гэрээг шилжүүлэн өгч түрээсийн зардал нь тус байгууллагын санхүүгийн тайланд тусгагдахаар байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Бусад асуудлын хэсэг:

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар нь 2021 онд байршуулбал зохих 7,909,311.3 мянган төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод бүрэн байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн тайлант онд 2 төсөл арга, хэмжээний 91,997.1 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулсныг шалгахад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 103,022.5 мянган төгрөгийн 10 алдаа зөрчил илрүүлснээс 91,209.3 төгрөгийн 8 алдааг залруулж, 11,813.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянахад 1,434.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн актын биелэлт 100.0 хувь, 129,641.5 мянган төгрөгийн 3 албан шаардлагын биелэлт 95.0 хувь, 16,148.1 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 95.0 хувьтай байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн албан шаардлагын хэрэгжилт /Мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1,434.8	1	1,434.8			100.0
Албан шаардлага	3	129,641.5	3	129,641.5			95.0
Зөвлөмж	2	16,148.1	2	16,148.1			95.0
Нийт дүн	6	147,224.4	6	147,224.4			96.6

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар нь 2022 оноос түрээсийн гэрээг өөрийн байгууллагын нэрээр үйлдэж, түрээсийн зардлыг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн эсэхийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 157,478.4 мянган төгрөгийн 14 алдаа зөрчил илэрснээс, 84,266.6 мянган төгрөгийн 9 алдааг залруулж, 73,211.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 5 алдаа, зөрчлийн дүн 73,211.8 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 79,730.5 мянган төгрөгөөс хэтрээгүй тул "Зөрчилгүй дүгнэлт" өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын 9 алдаатай холбоотой 84,266.6 мянган төгрөгийн алдааг залруулж дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайланд Төрийн сангийн харилцах дансны эхний үлдэгдэл 3,409.0 мянган төгрөгийг бусад төсөл нөөцийн харилцах ангилалд тайлагнасан;
- Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг бараа материал болон үндсэн хөрөнгөөр ангилахгүйгээр нэгтгэн тайлагнасан;
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх оны төвлөрүүлэх шилжүүлэг 265.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд тайлагнасан;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд урсгал санхүүжилтээс хүлээн авсан дүнг 3,329.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Нэмэлт санхүүжилтийн тайланд төвлөрүүлэх шилжүүлэг 280.6 мянган төгрөгийг дутуу тусгасан;
- Нийгмийн даатгалын тайланд 1,276.2 мянган төгрөгийн цалин хөлсийг дутуу тайлагнасан;
- Үйлчилгээний орлого дансыг 70,506.0 мянган төгрөгөөр бууруулан урьдчилж орсон орлого дансыг нэмэгдүүлэн алдаатай гүйлгээ хийсэн байна.
- Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг 0 жилээр оруулснаас 9 нэр төрлийн хөрөнгийн элэгдлийг 2,045.2 мянган төгрөгөөр дутуу байгуулсан;
- Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос суутгасан орлогын албан татварын тайланд 3,154.9 мянган төгрөгийн цалин хөлсийг илүү тайлагнасан зэрэг асуудлыг тус тус аудитаар залруулав.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Татварын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Татварын цахим системд тусгагдсан татварын өр авлагад тус компанид хамааралгүй үлдэгдлүүд илүү төлөлтөөр тусгагдсан буюу татварын цахим системд тусгагдсан үлдэгдлүүд нь үнэн зөв илэрхийлэгдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4-т "Үнэн зөв байх" тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Татварын цахим системд тусгагдсан татварын өр авлагын үлдэгдлийг залруулж санхүүгийн тайланд тусгагдсан үлдэгдлээс зөрүүгүй байдлаар тусгуулах;

2. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой 18 нэр төрлийн 44,304.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй

байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.3.2 "...элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, ... эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох;

3. Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн шинж чанартай 17,094.0 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна. Энэ нь УСНББОУС 12 Бараа материал стандартын "Бараа материал гэдэг нь хөрөнгүүд юм: а/Үйлдвэрлэлийн процесс-д ашиглан зарцуулагдах материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа б/Үйлчилгээ үзүүлэхэд ашиглан зарцуулагдах материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа в/Хэвийн үйл ажиллагааны явцад худалдан борлуулах буюу түгээн хуваарилах зорилгоор эзэмшиж байгаа" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн шинж чанартай 17,094.0 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын данснаас үндсэн хөрөнгийн данс руу шилжүүлэн бүртгэх, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх;

4. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

ТӨБЗГ-т балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн нэр төрөл, тоо хэмжээ, үнийн дүнг алдаатай хүргүүлснээс тушаалд тусгагдсан дүнгээс 11,813.2 мянган төгрөгөөр зөрүүтэй дүнгээр хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1-д "Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон бусад шаардлагаар төрийн өмчит хуулийн этгээд илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг шилжүүлэх, бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авахдаа өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авч, холбогдох баримт материалыг энэхүү журамд заасны дагуу бүрдүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ." гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангаж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

ТӨБЗГ-ын тогтоол, шийдвэрт тусгагдсан хөрөнгийн нэр төрөл, тоо хэмжээ, үнийн дүнгээс зөрүүгүй байдлаар хөрөнгийг бүртгэлд тусгах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх;

5. Төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгээгүй, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга, тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийг тус тус аудитад ирүүлээгүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.5 "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна" 54.5.4 "хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга", 54.5.3 "тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна

Өгсөн зөвлөмж:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу иж бүрэн, үнэн зөв бэлтгэн гаргах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс				
					тоо	Дүн	Залруулга		Акт	Албан шаардлага	Зөвлөмж
							тоо	Дүн			
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар											
1	Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар	ХАК-2022/783/НА-СА-ТШЗ	Төрийн сангийн харилцах дансны эхний үлдэгдэл 3,409.0 мянган төгрөгийг бусад төсөл нөөцийн харилцах ангилалд тайлагнасан	Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэлд тусгаж залруулсан	1	3,409.0	1	3,409.0			
2	Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар	ХАК-2022/783/НА-СА-ТШЗ	Үнэ төлбөргүй хүтээн авсан орлогыг бараа материал болон үндсэн хөрөнгөөр ангилахгүйгээр нэгтгэн тайлагнасан	Ангилал тус бүрээр задлан залруулсан	1		1				
3	Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар	ХАК-2022/783/НА-СА-ТШЗ	Санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх оны төвлөрүүлэх шилжүүлэг 265.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд тайлагнасан	Төвлөрүүлэх шилжүүлгийн ангилалд бүртгэж залруулсан	1	265.0	1	265.0			
4	Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар	ХАК-2022/783/НА-СА-ТШЗ	Төсвийн гүйцэтгэлийн тайланд урсгал санхүүжилтээс хүлээн авсан дүнг 3,329.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан	Урсгал санхүүжилтийг 3,329.7 мянган төгрөгөөр бууруулан залруулсан	1	3,329.7	1	3,329.7			
5	Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар	ХАК-2022/783/НА-СА-ТШЗ	Нэмэлт санхүүжилтийн тайланд төвлөрүүлэх шилжүүлэг 280.6 мянган төгрөгийг дутуу тусгасан	Нэмэлт санхүүжилтийн тайланд төвлөрүүлэх шилжүүлэг 280.6 мянган төгрөгийг тусгасан	1	280.6	1	280.6			
6	Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар	ХАК-2022/783/НА-СА-ТШЗ	Нийгмийн даатгалын тайланд 1,276.2 мянган төгрөгийн цалин хөлсийг дутуу тайлагнасан	Нийгмийн даатгалын тайланд 1,276.2 мянган төгрөгийн цалин хөлсийг нэмж тайлагнан залруулсан	1	1,276.2	1	1,276.2			
7	Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар	ХАК-2022/783/НА-СА-ТШЗ	Үйлчилгээний орлого дансыг 70,506.0 мянган төгрөгөөр бууруулан урьдчилж орсон орлого дансыг нэмэгдүүлэн алдаатай гүйлгээ хийсэн байна	Орлого бууруулсан бичгийг залруулсан	1	70,506.0	1	70,506.0			
8	Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар	ХАК-2022/783/НА-СА-ТШЗ	Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг 9 нэр төрлийн хөрөнгийн элэгдлийг 2,045.2 мянган төгрөгөөр дутуу байгуулсан	Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг тусгуулж элэгдлийг залруулсан	1	2,045.2	1	2,045.2			
9	Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар	ХАК-2022/783/НА-СА-ТШЗ	Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос суутгасан орлогын албан татаарын тайланд 3,154.9 мянган төгрөгийн цалин	Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос суутгасан орлогын албан татаарын тайланд 3,154.9 мянган төгрөгийн цалин	1	3,154.9	1	3,154.9			

		хөлсийг илүү тайланасан зэрэг асуудлыг тус тус аудитаар зааруулав	хөлсийг бууруулан тайлагнаж зааруулсан																
10	Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар	ХАК-2022/783/НА-СА-ТШЗ	Татварын цахим системд тусгагдсан татварын өр авлагад тус компанид хамааралгүй үлдэгдлүүд илүү төлөлтөөр тусгагдсан буюу татварын цахим системд тусгагдсан үлдэгдлүүд нь үнэн зөв илэрхийлэгдээгүй байна	Татварын цахим системд тусгагдсан татварын өр авлагын үлдэгдлийг зааруулж санхүүгийн тайланд тусгагдсан үлдэгдлээс зөрүүгүй байдлаар тусгуулах	1												1		
11	Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар	ХАК-2022/783/НА-СА-ТШЗ	Эзлэгдээрээ анхны өртөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой 18 нэр төрлийн 44,304.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох	Эзлэгдээрээ анхны өртөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох	1					44,304.6							1		44,304.6
12	Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар	ХАК-2022/783/НА-СА-ТШЗ	Үндсэн хөрөнгийн шинж чанартай 17,094.0 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна.	Үндсэн хөрөнгийн шинж чанартай 17,094.0 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын данснаас үндсэн хөрөнгийн данс руу шилжүүлэн бүртгэх, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх;	1					17,094.0							1		17,094.0
13	Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар	ХАК-2022/783/НА-СА-ТШЗ	ТӨБЗГ-т балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн нэр төрөл, тоо хэмжээ, үнийн дүнг алдаатай хүргүүлснээс тушаалд тусгагдсан дүнгээс 11,813.2 мянган төгрөгөөр зөрүүтэй дүнгээр хүлээн зөвшөөрч бүртгэсэн	ТӨБЗГ-ын тогтоол, шийдвэрт тусгагдсан хөрөнгийн нэр төрөл, тоо хэмжээ, үнийн дүнгээс зөрүүгүй байдлаар хөрөнгийг бүртгэлд тусгах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх	1					11,813.2							1		11,813.2
14	Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар	ХАК-2022/783/НА-СА-ТШЗ	Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгээгүй, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга, тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийг тус тус аудитад ирүүлээгүй	Төсвийн гүйцэтгэлийн тайланг тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу иж бүрэн, үнэн зөв бэлтгэн гаргах	1												1		
Дүн					14	157,478.4	9	84,266.6	0	0	0	0	0	0	0	0	5		73,211.8